

# “ШИНЭ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ” ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД 2018 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2019.03.06

Улаанбаатар хот

## Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, арга зүй

“Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хүрээнд Авто замын салбарт хэрэгжсэн гурав, Авто тээврийн салбарт хэрэгжсэн гурван зорилтод тусгагдсан нийт 33 арга хэмжээний хэрэгжилтэд 2018 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар зөвлөмж боловсруулан, хэрэгжилтийн үр дүн, хариуцлагыг сайжруулахад энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго оршино.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”- ыг баримталсан.

## Хоёр. Хамарсан хүрээ

Дээрх хөтөлбөр, зорилтын хүрээнд Зам, тээврийн салбарт хэрэгжсэн 33 арга хэмжээг хамруулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. **Үүнд:**

1. Авто замын салбарт 3-н зорилтын хүрээнд
  - 1.1. “Улаанбаатар хотыг аймгийн төвүүдтэй, аймгийн төвүүдийг ойролцоох хилийн боомтуудтай холбосон 5572 км авто зам барих” зорилтын хүрээнд 23 арга хэмжээ;
  - 1.2. “Улаанбаатар хотын авто замын 1, 2, 3 дугаар тойрог замыг шинээр бий болгох, тойрог замыг холбосон туслах зам, хотын алслагдсан дүүрэг, шинээр баригдсан орон сууцны цогцолбор хорооллуудыг холбосон авто зам барих” зорилтын хүрээнд 3 арга хэмжээ;
  - 1.3. “Алтанбулаг-Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн 990 км хурдны замыг барьж ашиглалтад оруулах” 1 арга хэмжээг тус тус хамруулсан.
2. Авто тээврийн салбарт 3-н зорилтын хүрээнд
  - 2.1 “Нийтийн тээврийн том оврын 800, бага оврын 1500 автобусыг шингэрүүлсэн хийн түлшинд шилжүүлэх” зорилтын хүрээнд 3 арга хэмжээ;
  - 2.2 “Тусгай замын автобусны үйлчилгээ, их багтаамжийн нийтийн тээврийн бусад төрлийг нэвтрүүлэх боломжийг судлах” зорилтын хүрээнд 1 арга хэмжээ;
  - 2.3 “Эхний ээлжинд 50 дуобус үйлдвэрлэхийн зэрэгцээ дизель хөдөлгүүртэй хуучин 100 автобусыг цахилгаан хөдөлгүүртэй болгох” зорилтын хүрээнд 2 арга хэмжээг тус тус хамруулсан.

## Гурав. Үнэлгээ

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу дээрх хөтөлбөр, зорилтын хүрээнд Зам, тээврийн салбарт хэрэгжсэн 33 арга хэмжээний хэрэгжилтэд 2018 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дундаж дүн нь 37.3 %-тай байна. **Үүнээс:**

Авто замын салбарт 27 арга хэмжээ төлөвлөснөөс 2018 оны жилийн эцсийн байдлаар 100%-ийн биелэлттэй 7, 70%-ийн биелэлттэй 4, 30%-ийн биелэлттэй 5, хэрэгжээгүй 11 арга хэмжээний хэрэгжилтийн дүн дунджаар 41,9%-ийн биелэлттэй байна.

Авто тээврийн салбарт 6 арга хэмжээ төлөвлөснөөс 2018 оны жилийн эцсийн байдлаар 70%-ийн биелэлттэй 1, хэрэгжээгүй 5 арга хэмжээний хэрэгжилтийн дүн дунджаар 11,7 %-ийн биелэлттэй байна.

### Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн товчоо

№	Салбарын нэр	Арга хэмжээ ний тоо	Хэрэгжилтийн түвшин				Биелэлтийн дүн (хувиар)
			100%	70%	30%	0%	
1	Авто замын салбар	27	7	4	5	11	41,9
2	Авто тээврийн салбар	6	-	1	-	5	11.7
<b>Бүгд</b>		<b>33</b>	<b>8</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>16</b>	<b>37.3</b>

## Дөрөв. Дүгнэлт

“Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хүрээнд Зам, тээврийн салбарт 33 арга хэмжээ хэрэгжихээс 17 нь хэрэгжсэнээр дараах үр дүнг үзүүлсэн байна. **Үүнд:**

1. Шинээр авто зам баригдсанаар Нийслэлийг аймгийн төвүүдтэй холбосон авто замын дэд бүтэц сайжирлаа.
2. Хөтөлбөрийн хүрээнд олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээ нэмэгдэж Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшилж, зорчигчдод цэвэр, тохилог, орчин үеийн технологийн шийдэл бүхий нийтийн тээврийн хэрэгслээр зорчих нөхцөл бүрдэж, тээврийн хэрэгсэлийн шатахуун зарцуулалт, зорчих хугацаа багасч байна.
3. Хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотод авто зам, гүүрэн гарцууд шинээр баригдсанаар авто замын хөдөлгөөний түгжрэл буурч, хөдөлгөөний аюулгүй байдал сайжран, зорчигчдын тав тух сайжирсан зэрэг эерэг нөлөөг бий болгож байна.
4. Тээврийн хэрэгсэл нь ердийн хөрсөн замаар зорчдог байсан нутаг дэвсгэрт шинээр авто зам баригдсанаар олон салаа замууд арилж, тодорхой хугацааны дараа ургамлын бүрхэвч бий болж, бэлчээрийн талбайг нэмэгдүүлэн, тоосжилт буурах...зэрэг байгаль орчинд эерэг нөлөөг үзүүлж эхлээд байна.

5. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн арга хэмжээнүүдэд Авто замын салбарын мэргэжлийн компаниуд ерөнхий болон туслан гүйцэтгэгчээр ажилласнаар инженер техникийн, мэргэжлийн ажилчдын мэргэжлийн ур чадвар, туршлага нэмэгдэж, үндэсний аж ахуйн нэгжүүдийн чадавх сайжирч, түр болон байнгын ажлын байр нэмэгдсэн байна.

#### **Тав. Санал, зөвлөмж**

1. “Засгийн газрын 2016-2020 үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй, “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хүрээнд 2010-2016 онд хэрэгжээд зогссон болон хэрэгжиж эхлээгүй 11 арга хэмжээ (Нэг.”Авто замын салбар” бүлгийн 4, 6, 9, 15, 16, 17, 20, 21, 22, 23 дугаартай, ”Хурдны зам” бүлгийн 1 дугаартай арга хэмжээ), зогсонги байдалд ороод байгаа Улиастай-Тосонцэнгэл чиглэлийн 67 км авто замын барилгын ажлын санхүүжилтийг шийдвэрлүүлэх.
2. Хөтөлбөр, зорилтын хүрээнд авто замын салбарт хэрэгжиж буй зарим арга хэмжээний хувьд “Гадаадаас авч ажиллуулах ажиллах хүчний зөвшөөрөл”-ийг цаг алдалгүй гаргаж, ажлыг төлөвлөгөөний дагуу хэрэгжих нөхцлийг бүрдүүлэх.
3. Төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд авто замын сүлжээний урт нэмэгдэж байгаа нь сайн талтай ч авто замын засвар, арчилалтад зарцуулахаар төлөвлөсөн хөрөнгө жил бүрийн Улсын төсөвт хасагдан сууж байгааг анхаарах.
4. Цаашид Зам, тээврийн салбарт шинээр хэрэгжих хөтөлбөр, арга хэмжээнүүдэд үндэсний аж ахуйн нэгжүүдийн оролцох хувийг нэмэгдүүлэх.

#### **ТАНИЛЦСАН:**

САЙД

Б.ЭНХ-АМГАЛАН

ДЭД САЙД

Л.ХАЛТАР

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.БАТБОЛД

#### **ХЯНАСАН:**

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД  
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

М.ЭНХБОЛД

#### **ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:**

АВТО ЗАМЫН САЛБАРЫН БОДЛОГО, ХӨТӨЛБӨР,  
ТӨСЛИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД  
АУДИТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.ГАНТӨМӨР